



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 22 өдөр

Дугаар А/422

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 “б”, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн “Зорилтот жилийн төлөвлөгөө батлах тухай” А/31 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих жил”-ийн хүрээнд “Өв агро гурил тэжээлийн үйлдвэр” орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн тариалсан ногоон тэжээлийг хураан авахад шаардагдах боодлын мяндасны зардалд 11,700,000 (арван нэгэн сая долоон зуун мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх 11,700,000 (арван нэгэн сая долоон зуун мянга) төгрөгийн зардлыг өвс, тэжээлийн аюулгүй нөөц бэлтгэх хөрөнгийн эргэн төлөлтөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100900